



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дундговь аймгийн Говь-Угтаал сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ДУА-2022/63/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn</p> <p>Мандалговь хот</p> <p>2022 он</p>	<p>Дарга,тэргүүлэх аудитор: Р.Мөнхтогтох</p> <p>Утас: 70592439</p> <p>Цахим хаяг: Munkhtogtokhr@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер: Х.Наранцацрал</p> <p>Утас: 70592225</p> <p>Цахим хаяг: Narantsatsralkh@audit.gov.mn</p> <p>Ахлах аудитор: Т.Батсайхан</p> <p>Утас: 70593113</p> <p>Цахим хаяг: batsaikhant@audit.gov.mn</p> <p>Аудитор: Т.Оюун-Эрдэнэ</p> <p>Утас: 70593113</p> <p>Цахим хаяг: Oyunerdenet@audit.gov.mn</p>
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт.....	3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	5
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	7
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	9
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	10
3. Аудитын тайлан.....	11
3.1 Ерөнхий зүйл.....	11
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт.....	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	11
3.4 Материаллаг байдал.....	12
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	12
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	13
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	14
3.8 Аудитын гол асуудал.....	14
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	14
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	14
3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд.....	14
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	15
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	15
4. Аудитын илрүүлэлт.....	15
4.1 Залруулсан алдаа.....	15
4.2 Төлбөрийн акт.....	15
4.3 Албан шаардлага.....	15
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл.....	16

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ЗГНХ	Засгийн газрын нөөц хөрөнгө
ЗДНХ	Засаг даргын нөөц хөрөнгө

1. Аудитын санал дүгнэлт



**ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
48090 Дундговь аймаг, Сайнцагаан сум
Утас: 70592439, 70592208, 70593208
И-мэйл: dundgovi@audit.gov.mn

**ДУНДГОВЬ АЙМГИЙН ГОВЬ-УГТААЛ
СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН
СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ
Т.УРАНЧИМЭГ ТАНАА**

2022.02.23 № 21
танай _____ -ны № _____ -т

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дундговь аймгийн Говь-Угтаал сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дундговь аймгийн Говь-Угтаал сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага


Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

0012020719

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Р.МӨНХТОГТОХ

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>88,388,353.62</u>	<u>63,120,757.62</u>
33	АВЛАГА	33,122,000.00	-
335	Бусад авлага	33,122,000.00	-
3351	Байгууллагаас авах авлага	33,122,000.00	-
35	БАРАА МАТЕРИАЛ	55,266,353.62	63,120,757.62
351	Түүхий эд материал	29,991,750.35	30,141,750.35
35110	Тусгай зориулалттай материал	29,991,750.35	29,991,750.35
35130	Эм боох материал	-	150,000.00
354	Хангамжийн материал	25,274,603.27	32,979,007.27
35410	Бичиг хэргийн материал	256,000.00	1,788,000.00
35420	Аж ахуйн материал	21,320,197.27	26,045,097.27
35440	Түлш, шатах тослох материал	71,800.00	-
35450	Барилгын засварын материал	2,550,000.00	4,530,000.00
35460	Хүнсний материал	1,076,606.00	615,910.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>1,084,040,469.51</u>	<u>1,092,990,516.71</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,084,040,469.51	1,092,990,516.71
391	Газар		
392	Биет хөрөнгө	1,046,734,469.51	1,055,850,662.50
39201	Барилга, байгууламж, орон сууц	983,286,802.42	983,286,802.42
39202	Хуримтлагдсан элэгдэл	(38,600,303.97)	(59,034,159.09)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	17,888,320.04	17,888,320.04
39204	Хуримтлагдсан элэгдэл	(10,434,853.45)	(14,012,517.49)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	97,812,672.04	104,236,192.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(52,899,561.05)	(53,789,519.16)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	67,615,561.44	96,160,331.44
39208	Хуримтлагдсан элэгдэл	(33,587,545.72)	(39,635,855.46)
39217	Ном	15,653,377.76	20,751,067.80
393	Биет бус хөрөнгө	37,306,000.00	37,139,854.21
39301	Програм хангамж	220,000.00	275,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-	(221,145.79)
39303	Бусад биет бус хөрөнгө	37,086,000.00	37,086,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>1,172,428,823.13</u>	<u>1,156,111,274.33</u>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>1,172,428,823.13</u>	<u>1,156,111,274.33</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	1,172,428,823.13	1,156,111,274.33
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	547,280,406.90	547,280,406.90
51101	Өмч: - төрийн	547,280,406.90	547,280,406.90
512	Хуримтлагдсан үр дүн	(384,069,325.40)	(400,386,874.20)
51210	Өмнөх үеийн үр дүн	(384,069,325.40)	(384,069,325.40)
51220	Тайлант үеийн үр дүн	-	(16,317,548.80)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,009,217,741.63	1,009,217,741.63
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>1,172,428,823.13</u>	<u>1,156,111,274.33</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	<u>596,531,329.74</u>	<u>588,262,943.04</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	<u>19,697,729.74</u>	<u>18,335,190.04</u>
120	Нийтлэг татварын бус орлого	19,697,729.74	18,335,190.04
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	19,697,729.74	18,335,190.04

1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	19,697,729.74	18,335,190.04
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	576,833,600.00	569,927,753.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	470,468,100.00	453,029,100.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	470,468,100.00	453,029,100.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	717,000.00	5,900,753.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	150,000.00	4,634,453.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	567,000.00	1,266,300.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	105,648,500.00	110,997,900.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	105,648,500.00	110,997,900.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	586,459,845.92	604,580,491.84
21	УРСГАЛ ЗАРДАЛ	586,459,845.92	604,580,491.84
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	562,785,518.92	578,671,648.84
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	341,619,037.00	340,216,712.00
210101	Үндсэн цалин	250,533,371.00	245,848,822.00
210102	Нэмэгдэл	64,524,039.00	66,306,583.00
210104	Урамшуулал	26,561,627.00	28,061,307.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	42,705,942.00	44,716,014.00
210201	Тэтгэврийн даатгал	29,426,439.00	31,084,477.00
210202	Тэтгэмжийн даатгал	3,462,243.00	3,442,097.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,722,756.00	2,763,345.00
210204	Ажилгүйдлийн даатгал	642,569.00	821,831.00
210205	Эрүүл мэндийн даатгал	6,451,935.00	6,604,264.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	101,789,916.00	104,908,206.00
210301	Гэрэл, цахилгаан	2,981,921.00	2,723,744.00
210302	Түлш, халаалт	98,807,995.00	102,184,462.00
2104	Хангамж, бараа материалын зардал	10,373,999.20	4,878,550.00
210401	Бичиг хэрэг	639,000.00	1,042,000.00
210402	Тээвэр, шатахуун	1,542,300.00	1,890,650.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	698,500.00	638,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,746,510.00	1,307,900.00
210408	Бараа материал актальсны зардал	3,747,689.20	-
2105	Нормативт зардал	10,054,152.00	9,360,084.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	466,970.00	633,175.00
210502	Хоол, хүнс	9,587,182.00	8,726,909.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	3,844,880.00
210604	Урсгал засвар	-	3,844,880.00
2107	Томилолт, зочны зардал	2,762,100.00	1,250,000.00
210702	Дотоод албан томилолт	2,762,100.00	1,250,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,803,750.00	430,600.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	990,000.00	-
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	432,000.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	119,250.00	119,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	9,500.00	38,600.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	33,000.00	33,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	220,000.00	240,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	51,676,622.72	69,066,602.84
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,787,000.00	5,550,700.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,274,000.00	5,732,960.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	48,615,622.72	57,782,942.84
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	23,674,327.00	25,908,843.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	8,179,470.00	17,202,926.00
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	-	2,000,000.00

213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	7,595,370.00	12,691,626.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	584,100.00	2,511,300.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	1,158,584.00	264,814.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,158,584.00	264,814.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	14,336,273.00	8,441,103.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	14,336,273.00	8,441,103.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	10,071,483.82	(16,317,548.80)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	10,071,483.82	(16,317,548.80)

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	547,280,406.90	1,009,217,741.63	(394,140,809.22)	1,162,357,339.31
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	547,280,406.90	1,009,217,741.63	(394,140,809.22)	1,162,357,339.31
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	10,071,483.82	10,071,483.82
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	547,280,406.90	1,009,217,741.63	(384,069,325.40)	1,172,428,823.13
D01	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	547,280,406.90	1,009,217,741.63	(384,069,325.40)	1,172,428,823.13
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	547,280,406.90	1,009,217,741.63	(384,069,325.40)	1,172,428,823.13
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	547,280,406.90	1,009,217,741.63	(384,069,325.40)	1,172,428,823.13
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	(16,317,548.80)	(16,317,548.80)
D09	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	547,280,406.90	1,009,217,741.63	(400,386,874.20)	1,156,111,274.33

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	576,833,600.00	569,927,753.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	576,833,600.00	569,927,753.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	470,468,100.00	453,029,100.00

131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	470,468,100.00	453,029,100.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	717,000.00	5,900,753.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	150,000.00	4,634,453.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	567,000.00	1,266,300.00
131106	Төсвийн урамшуулал		
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	105,648,500.00	110,997,900.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт / орон нутгийн төсөвт байгууллага/	105,648,500.00	110,997,900.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	571,277,700.00	554,291,953.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	571,277,700.00	554,291,953.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	547,603,437.00	528,383,110.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	341,619,037.00	340,216,712.00
210101	Үндсэн цалин	250,533,371.00	245,848,822.00
210102	Нэмэгдэл	64,524,039.00	66,306,583.00
210104	Урамшуулал	26,561,627.00	28,061,307.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	42,705,942.00	44,716,014.00
210201	Тэтгэврийн даатгал	29,426,439.00	31,084,477.00
210202	Тэтгэмжийн даатгал	3,462,243.00	3,442,097.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,722,756.00	2,763,345.00
210204	Ажилгүйдлийн даатгал	642,569.00	821,831.00
210205	Эрүүл мэндийн даатгал	6,451,935.00	6,604,264.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	101,789,916.00	104,908,206.00
210301	Гэрэл, цахилгаан	2,981,921.00	2,723,744.00
210302	Түлш, халаалт	98,807,995.00	102,184,462.00
2104	Хангамж, бараа материалын зардал	10,057,700.00	5,377,650.00
210401	Бичиг хэрэг	909,000.00	955,500.00
210402	Тээвэр, шатахуун	1,614,100.00	1,818,850.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	698,500.00	638,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,836,100.00	1,965,300.00
2105	Нормативт зардал	10,219,992.00	11,154,388.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	416,810.00	783,175.00
210502	Хоол, хүнс	9,587,182.00	8,266,213.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	216,000.00	2,105,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	34,850,000.00	7,427,380.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	300,000.00	1,602,500.00
210602	Тавилга	31,850,000.00	-
210604	Урсгал засвар	2,700,000.00	5,824,880.00
2107	Томилолт, зочны зардал	2,762,100.00	1,250,000.00
210702	Дотоод албан томилолт	2,762,100.00	1,250,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,803,750.00	430,600.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	990,000.00	-
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	432,000.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	119,250.00	119,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	9,500.00	38,600.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	33,000.00	33,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	220,000.00	240,000.00

2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,795,000.00	12,902,160.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	5,550,700.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,795,000.00	7,351,460.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	23,674,263.00	25,908,843.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	8,179,406.00	17,202,926.00
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	-	2,000,000.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	7,595,306.00	12,691,626.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	584,100.00	2,511,300.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	1,158,584.00	264,814.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,158,584.00	264,814.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	14,336,273.00	8,441,103.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	14,336,273.00	8,441,103.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	5,555,900.00	15,635,800.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	5,555,900.00	15,635,800.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	5,555,900.00	15,635,800.00
2200	Дотоод эх үүсвэрээр	5,555,900.00	15,635,800.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	5,555,900.00	15,635,800.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(5,555,900.00)	(15,635,800.00)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	00.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	564,027,000.0	555,321,196.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	564,027,000.0	555,321,196.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	545,949,900.0	539,384,570.0
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	344,041,300.0	340,216,712.0
210101	Үндсэн цалин	249,094,800.0	245,848,822.0
210102	Нэмэгдэл	66,344,300.0	66,306,583.0
210104	Урамшуулал	28,602,200.0	28,061,307.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	45,439,400.0	44,716,014.0
210201	Тэтгэврийн даатгал	31,196,700.0	31,084,477.0
210202	Тэтгэмжийн даатгал	3,570,000.0	3,442,097.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,873,000.0	2,763,345.0
210204	Ажилгүйдлийн даатгал	869,000.0	821,831.0
210205	Эрүүл мэндийн даатгал	6,930,700.0	6,604,264.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	105,111,100.0	104,908,206.0
210301	Гэрэл, цахилгаан	2,926,600.0	2,723,744.0
210302	Түлш, халаалт	102,184,500.0	102,184,462.0

2104	Хангамж, бараа материалын зардал	5,879,400.0	5,543,150.0
210401	Бичиг хэрэг	881,600.0	879,000.0
210402	Тээвэр, шатахуун	1,828,400.0	1,818,850.0
210404	Ном, хэвлэл	242,000.0	242,000.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	638,000.0	638,000.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,289,400.0	1,965,300.0
2105	Нормативт зардал	12,298,000.0	10,896,508.0
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	525,300.0	525,295.0
210502	Хоол, хүнс	9,639,900.0	8,266,213.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,132,800.0	2,105,000.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	22,828,100.0	22,766,180.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	16,941,300.0	16,941,300.0
210604	Урсгал засвар	5,886,800.0	5,824,880.0
2107	Томилолт, зочны зардал	1,258,900.0	1,250,000.0
210702	Дотоод албан томилолт	1,258,900.0	1,250,000.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	490,100.0	485,600.0
210803	Даатгалын үйлчилгээ	119,000.0	119,000.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	43,100.0	38,600.0
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	33,000.0	33,000.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	295,000.0	295,000.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	8,603,600.0	8,602,200.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5,550,700.0	5,550,700.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,052,900.0	3,051,500.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	18,077,100.0	15,936,626.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	18,077,100.0	15,936,626.0
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	2,000,000.0	2,000,000.0
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	14,831,900.0	12,691,626.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,245,200.0	1,245,000.0
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	564,027,000.0	555,321,196.0
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	453,029,100.0	444,587,997.0
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	453,029,100.0	444,587,997.0
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	110,997,900.0	110,733,199.0
122005	Орон нутгийн төсвөөс	110,997,900.0	110,733,199.0
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	5,900,640.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	5,900,640.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4,634,340.00
2104	Хангамж, бараа материалын зардал	76,500.00
210401	Бичиг хэрэг	76,500.00
2105	Нормативт зардал	257,880.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	257,880.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	4,299,960.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,299,960.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,266,300.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,266,300.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,266,300.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	113.00
213503	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг	113.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	5,900,753.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	5,900,753.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод	4,634,453.00

	шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,266,300.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Дундговь аймгийн Говь-Угтаал сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг аудитор Т.Оюун-Эрдэнэ гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Наранцацрал, дарга, тэргүүлэх аудитор Р.Мөнхтогтох нар тус тус хэрэгжүүлсэн.

Дундговь аймгийн Говь-Угтаал сумын Ерөнхий боловсролын сургууль 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Дундговь аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 21-ний өдрийн 01 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 БАЙГУУЛЛАГА, ТҮҮНИЙ ОРЧИН БА ДОТООД ХЯНАЛТ

Дундговь аймгийн Говь-Угтаал сумын Ерөнхий боловсролын сургууль нь эрхэм зорилгоо “Зөв дадал хэвшилтэй, бие даан суралцах чадвартай иргэн төлөвшүүлэх, Ирээдүйд ажиллаж амьдрах чадвартай, төрөлх шинж авьяас бодит чадварыг хөгжүүлэх, нийгэмшүүлж сургахад зайлшгүй шаардлагатай нээлттэй хөгжингүй орчныг бүрдүүлэхэд оршино” гэж тодорхойлжээ.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Тайлант онд Санхүүгийн хяналт, аудитын албанаас хяналт, шалгалт хийгдсэн. Хяналт, шалгалтын дүнд 1 төлбөрийн акт, 4 зөвлөмж өгөгдсөн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд тусалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн

тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Дундговь аймгийн Говь-Угтаал сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 604,580.5 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 6,045.8 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 4,232.1 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

Дундговь аймгийн Говь-Угтаал сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 16,317.5 мянган төгрөгөөр буюу 1.4 хувиар буурсан байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлагын данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

	/мянган төгрөг/		
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	33,122.0	-	(33,122.0)
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	55,266.4	63,120.8	7,854.4
Үндсэн хөрөнгө	1,084,040.5	1,092,990.5	8,950.0
Нийт хөрөнгө	1,172,428.8	1,156,111.3	(16,317.5)
Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	1,172,428.8	1,156,111.3	(16,317.5)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,172,428.8	1,156,111.3	(16,317.5)

Өмнөх онд сурагчийн ширээ сандал худалдан авч авлагаар тайлагнасныг тайланд онд хөрөнгийг хүлээн авч авлагыг хаасантай холбоотой авлагын данс буурсан байна.

Үндсэн хөрөнгийн дансанд төсвийн хөрөнгөөр худалдан авсан 15,635.8 мянган төгрөг, үнэ төлбөргүй хүлээн авсан 18,335.2 мянган төгрөг, авлага хааж 37,762.0 мянган төгрөгийн хөрөнгийг орлого авч, 26,612.0 мянган төгрөгийн хөрөнгийг актлан данснаас хассан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,156,111.3 мянган төгрөг болж 16,317.5 мянган төгрөгөөр буурсан нь тайлант оны үр дүн буурснаас шалтгаалжээ.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 592,799.1 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 592,799.1 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 28,772.1 мянган төгрөгөөр бууруулан 564,027.0 мянган төгрөгөөр баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 9 арга хэмжээг санхүүжүүлэхээр улсын төсвөөс 453,029.1 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 110,997.9 мянган төгрөг, нийт 564,027.0 мянган төгрөгийн төсөв батлагдсан байна.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 564,027.0 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд нийт төсвийн 98.5 хувийг зарцуулж, 264.8 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт, 8,441.1 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 555,321.2 мянган төгрөг буюу 98.5 хувьтай байгаа нь цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардал, төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшууллын зардлын гүйцэтгэл дутуу зарцуулагдсан. Энэ нь батлагдсан орон тооноос дутуу ажилтантай үйл ажиллагаагаа явуулсантай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Дээд шатны төсөв захирагчаас 4,634.5 мянган төгрөг, төсвийн байгууллагын үндсэн болон нэмэлт үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 1,266.3 мянган төгрөг, нийт 5,900.8 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс хангамж бараа материалын зардалд 76.5 мянган төгрөг, нормативт зардалд 257.9 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 4,300.0 мянган төгрөг, урсгал шилжүүлэгт 1,266.3 мянган төгрөг, нийт 5,900.7 мянган төгрөгийг зарцуулж, орон нутгийн төсөвт 0.1 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 АСУУДЛЫГ ОНЦОЛСОН ХЭСЭГ БА БУСАД АСУУДЛЫН ХЭСЭГ

Тайлант онд тус байгууллагын үйл ажиллагаанд дараах онцлох асуудлууд байна. Үүнд:

1. Дулааны эрчим хүчний үйлчилгээг Ган-Илч ХХК-тай гэрээ байгуулан авдаг байна. Тайлант онд Эрчим хүчний зохицуулах хорооны 2021 оны 10 дугаар 14-ний өдрийн 468 тогтоолоор халаалтын үнийг м³ тутамд 1500 төгрөг болгон өсгөснөөс Ган-Илч ХХК нь 107,613.3 мянган төгрөгийн нэхэмжлэхийг ирүүлсэн боловч гэрээнд өөрчлөлт оруулаагүй тул хуучин гэрээний үнэ 102,184.5 мянган төгрөгийг шилжүүлсэн байна.
2. БСШУЯ-аас хэрэгжүүлж байгаа Багшийн хөгжил шавьд сургуулийн тэтгэлэгт хөтөлбөрт хамрагдан 4,299.9 мянган төгрөгийн санхүүжилт авсан байна. Хөтөлбөрийн дагуу бага ангийн 105 сурагчдад цахимаар хичээл хийх нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор 1,963.0 мянган төгрөгөөр флаш худалдан авч тараасан, үлдсэн санхүүжилтийг “Багш хөгжлийн институтээс багш нарын ур чадварыг нэмэгдүүлэх сургалтуудыг авсан байна.

3.8 АУДИТЫН ГОЛ АСУУДАЛ

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад материаллаг буруу тайлагналын өндөр үнэлэгдсэн эрсдэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал, тайлант хугацаанд гарсан нөлөө бүхий ажил гүйлгээ, үйл явдал байхгүй тул гол асуудал байхгүй гэж үзлээ.

3.9 САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТААР ШАЛГАСАН НИЙЦЛИЙН АУДИТЫН АСУУДАЛ

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 ШИЛЭН ДАНСНЫ ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг шилэн дансны цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Дундговь аймгийн Говь-Угтаал сумын Ерөнхий боловсролын сургууль нь 2021 онд нийт 750,158.6 мянган төгрөгийн 165 мэдээллийг шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд ил тод, бүрэн байршуулахаас 2 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

3.9.2 БУСАД ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХҮРЭЭНД

Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Эрчим хүчний зохицуулах хорооны 2018 оны 292 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Аж ахуйн харилцааны дүрэм” зөрчсөн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлсэн.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, бусад хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт нийцээгүй гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар зөрчлийг арилгах 2 албан шаардлага, 224.1 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоосныг хэрэгжүүлэн, хэрэгжилтийг албан бичгээр ирүүлсэн байна.

3.11 ДАРААГИЙН АУДИТААР АНХААРАХ АСУУДАЛ

Цаг хугацааны хязгаарлагдмал байдлаас шалтгаалан үндсэн хөрөнгө, бараа материалын дансанд завсрын аудитаар хяналтын тооллого хэрэгжүүлэхээр шийдвэрлэлээ.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 351,747.4 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 350,510.9 мянган төгрөгийн алдааг залруулж, 159.8 мянган төгрөгийн зөрчил төлбөрийн акт тогтоож, 1,076.6 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлсэн.

4.1 Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

1. Цалингийн авлагыг 453.6 мянган төгрөгөөр илүү тайлагнасан;
2. Өмнөх оны аудитлагдсан үр дүн, мөнгөн гүйлгээний тайлангийн нийт зардлыг 277,927.5 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан.;
3. Өмнөх оны мөнгөн гүйлгээний тайлангийн нийт цэвэр мөнгөн гүйлгээг 72,129.8 мянган төгрөгөөр илүү тайлагнасан.

Шийдвэрлэсэн нь: Аудитын явцад нийт 350,510.9 мянган төгрөгийн залруулга хийсэн.

4.2 Төлбөрийн акт

Аудитаар илэрсэн дараах зөрчилд төлбөрийн акт тогтоолоо. Үүнд:

1. Сахилгын шийтгэлтэй албан хаагчдад 159.8 мянган төгрөгийн үр дүнгийн урамшуулал олгосон.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг барагдуулах төлбөрийн акт тогтоосон.

4.3 Албан шаардлага

Аудитаар илэрсэн дараах зөрчлүүдэд зөрчлийг давтан гаргахгүй байх хугацаатай албан шаардлагуудыг хүргүүллээ. Үүнд:

1. Хүнсний материалын үлдэгдлийг санхүүгийн тайлангаас 1,076.6 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан.
2. Агуулахын бүртгэл хөтлөөгүй.
3. Хагас жилийн хөрөнгийн тооллогыг хийсэн боловч тооцоог бодож баталгаажуулаагүй.
4. Сургуулийн дотуур байрны халаалтын төлбөрийг төсөв, үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллагын халаалтын тарифаар тооцон шилжүүлсэн.

Шийдвэрлэсэн нь: Нийт 1,076.6 мянган төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлсэн.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

д/ д	Алдаа, зөрчлийн агуулга	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		То о	Дүн	То о	Дүн	То о	Дүн	То о	Дүн	То о	Дүн
1. Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн хүрээнд:											
1	Сургуулийн дотуур байрны халаалтын төлбөрийг төсөв, үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллагын халаалтын тарифаар тооцон шилжүүлсэн.	1	-					1	-		
2. Бусад батламж мэдэгдлийн хүрээнд:											
1	Сахилгын шийтгэлтэй албан хаагчдад үр дүнгийн урамшуулал олгосон	1	159.8			1	159.8				
2	Хүнсний материалын үлдэгдэл санхүүгийн тайлангаас зөрүүтэй	1	1,076.6					1	1,076.6		
3	Агуулахын бүртгэл хөглөөгүй.	1	-					1	-		
4	Хагас жилийн хөрөнгийн тооллогыг хийсэн боловч тооцоог бодож баталгаажуулаагүй.	1	-					1	-		
5	Цалингийн авлагыг илүү тайлагнасан	1	453.6	1	453.6						
6	Өмнөх оны аудитлагдсан үр дүн, мөнгөн гүйлгээний тайлангийн нийт зардлыг дутуу тайлагнасан.	1	277,927.5	1	277,927.5						
7	Өмнөх оны мөнгөн гүйлгээний тайлангийн нийт цэвэр мөнгөн гүйлгээг илүү тайлагнасан.	1	72,129.8	1	72,129.8						
	Нийт зөрчлийн дүн	8	351,747.4	3.0	350,510.9	1.0	159.8	4.0	1,076.6	-	-